



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/66

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 2 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 34.3, 34.4 дахь 48 дугаар зүйлийн 48.2.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр санхүүжих “Мод усалгааны систем, нөөцийн сав”-ны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мягмаржав

Орлогч дарга

Нарийн бичиг: Б.Золзаяа

Цэцэрлэгийн багш

Гишүүд: Г.Мөнхцэцэг

Тамгын газрын нярав

2.Батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Мягмаржав)-д даалгасугай.

3.Худалдан авах ажилгаатай холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг нарийн бичиг (Б.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

